

ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ОБЪЕКТЫН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

*ДХИС-ийн магистрант, М.Ууганбаяр
ГТТАТ-ийн дэд профессор, ахмад Л.Булганхангай*


Хураангуй. Монгол оронд гарч байгаа гал түймрийн ихэнх хувийг нийслэл Улаанбаатар хотод гарч байгаа гал түймэр эзэлж байна. Энэ нь хүн амын төвлөрөл, нягтаршил үүнтэй холбоотойгоор хүний буруутай үйл ажиллагаа, хэнэггүй байдал, газрын буруу хуваарилалт буюу хот төлөвлөлт муу хийгдсэн байдал зэрэг нь гал түймэр гарах шалтгаан нөхцөлийг бий болгож байгаа юм. Тиймдээ ч гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг сайтар хангаж ажилладаг.

Харин хөдөө орон нутгийн хувьд нийслэл Улаанбаатар хотын гал түймрийн эзлэх хувьтай харьцуулахад бага байдаг. Тэгсэн хэдий ч гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байх шаардлагатай. Гэвч өнөөгийн байдалд хөдөө орон нутагт явуулж буй гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь үр дүн муутай байгаа нь нууц зүйл биш юм. Иймээс энэхүү илтгэлдээ хөдөө орон нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх ойлголтыг судлаж, хэрэгжиж байгаа үйл ажиллагааг сайжруулах талаар санал дэвшүүлэв.

Түлхүүр үг: Гал түймэр, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа, сургалт суртачилгаа, хөдөө орон нутаг

Оршил: Гал гэж шатах материал болон бодис, дулааны эх үүсвэр шүдэнз, лаа, цахилгаан, химийн урвал гэх мэт хүчилтөрөгч, агаар 3 харилцан үйлчлэлээр бий болдог гэрэл, дулаан ялгаруулдаг физик химийн үзэгдэл юм.

Гал түймэр гэж гал хараа хяналтаас гарч хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн хуулийн этгээдийн эд хөрөнгө байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг хэлнэ.



Объектын гал түймэр гэж бүх төрлийн өмчийн хэлбэрийн барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжид гарсан гал түймрийг хэлнэ.

Объектын гал түймэр гарах шалтгаан

- Цахилгаан байгууламжийн угсралт, ашиглалтын дүрэм зөрчигдсөнөөс;
- Пийшин, зуух, яндангийн гэмтлээс;
- Цогтой үнс нурмаа таггүй саванд хийснээс;
- Ил задгай гал, тамхи, шүдэнз, лаа, дэн, зул, хүж, арцыг дутуу унтрааж орхисон;
- Хялбар авалцан асах шатамхай шингэний буруу хэрэглээнээс;
- Гагнуур, паяльник, хөлдсөн хоолой шугамыг гэсгээх бамбарын галаас;
- Машин техникийн гэмтэл, ашиглалтын болон үйлдвэрлэлийн технологийн горим зөрчсөнөөс;

- Шингэрүүлсэн хийн тэсрэлт, аваар ослоос;
- Тэнхлэг цахилгаан болон очноос;
- Хүүхдийн болгоомжгүй үйл ажиллагаанаас;
- Архидан согтуурсны улмаас / санаатай /;
- Аянганаас;
- Орон сууцны барилгын хогийн хоолой;
- Галын онц аюултай бодис материал буруу ашигласан зэрэг;

Галын аюулгүй байдал гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдал.

Галын аюулгүй байдлын тухай хуулинд гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт суртачилгаа явуулах чиг үүргийг аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллага төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ гэж заасан байдаг бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд иргэн аж ахуй нэгж байгууллагын албан хаагчид, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн удирдах албан тушаалтнууд гал түймрээс урьдчилан сэргийлэх зохих түвшиний мэдлэгтэй байж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох дадлага туршлагатай байх шаардлагатай. Иймээс хөдөө орон нутгийн иргэд гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнгийн хүртээмж ямар түвшинд байгааг судлав.




График 1. МУ хэмжээнд 2021, 2022 онуудад гарсан нийт объектын гал түймрийн тоо
Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан




График 2. МУ хэмжээнд 2021, 2022 онуудад гамшгийн улмаас нас барсан хүний тоо
Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

2022 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 2281 объектын гал түймэр гарсан бөгөөд гамшгийн улмаас нас барсан хүний тоо 216, учирсан хохирлын хэмжээ 26,7 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан. Энэ оны судалгааг өнгөрсөн оны 1 дүгээр сараас 10 дугаар сар хүртлэх үетэй харьцуулахад гарсан гал түймрийн тоо 7,5% өссөн, нас барсан хүний тоо 24,5% буурсан, учирсан хохирлын хэмжээ 6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

Орон нутгийн иргэдээс авсан судалгааг нэгтгэн үзвэл гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан иргэдийн 50-аас дээш хувь нь ямар нэгэн байдлаар хамрагдсан боловч давтамжийн хувьд тогтмол биш буюу санал асуулгын нийт дүнгийн 48 хувийг 1-2 удаа хамрагдсан, 30 хувийг огт хамрагдаж байгаагүй гэсэн үзүүлэлт эзэлж байна. Энэ нь орон нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь бүс нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тогтмол хийгддэггүй бөгөөд иргэдийн идэвхи оролцоо сул байгааг харуулж байна.

Иймээс аймаг, нийслэлийн онцгой байдлын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлж гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн энэхүү судалгаанд хөдөө нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ямар хэлбэрээр явуулбал илүү хүртээмжтэй байлгах талаар судалгааны асуултанд тусгаж өгсөн бөгөөд санал асуулгын дийлэнх хувийг танхимын сургалт болон фейсбүүк сошиалаар мэдээлэл авах нь иргэдэд илүү хүртээмжтэй байна гэсэн үр дүн гарсан байна.

Санал

1. Орон нутагт нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах бааз болон мэргэжлийн алба хаагчийн хүртээмжийг сайжруулах;
2. Ард иргэдийн идэвхи оролцоо сул байгаа нэг шалтгаан нь фейсбүүк, сошиалаар хүргэж байгаа мэдээ мэдээлэл нь анхаарал татахуйц бус шинэлэг санаа дутмаг байгаа тул мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж онцгой байдлын байгууллага нь иргэд, аж ахуй нэгж байгууллагын дунд гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тэмцээн уралдааныг олон талаас нь зохион байгуулах;

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015
2. Гамшгийн эрсдэл судлал, онцгой байдлын сургуулийн онол, арга зүйн сэтгүүл, Улаанбаатар., 2019
3. Аюулгүй байдлын тогтолцоо, олон улсын эрдэм шинжилгээний эмхэтгэл, Улаанбаатар., 2022
4. Аюулгүй байдал судлал, эрдэм, шинжилгээний хурлын эмхэтгэл, Улаанбаатар., 2019
5. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан